

## **ОХУ-ЫН БҮГД НАЙРАМДАХ ХАЛИМАГ УЛСЫН ТЭРГҮҮН К.Н.ИЛЮМЖИНОВЫН МОНГОЛ УЛСАД ХИЙСЭН АЛБАН ЁСНЫ АЙЛЧЛАЛЫН ТУХАЙ ХЭВЛЭЛИЙН ХАМТАРСАН МЭДЭЭ**

Монгол Улсын Засгийн газрын урилгаар ОХУ-ын Бүгд Найрамдах Халимаг Улсын Тэргүүн К.Н.Илюмжинов 2009 оны хоёрдугаар сарын 2-4-ний өдрүүдэд Монгол Улсад албан ёсны айлчлал хийв. Төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд Бүгд Найрамдах Халимаг Улсын Засгийн газрын дарга В.Б.Сенглеев болон албаны бусад хүмүүс байв.

Айлчлалын үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаярт ОХУ-ын БНХалимаг Улсын Тэргүүн К.Н.Илюмжинов бараалхаж, хоёр улсын харилцааны байдал, төлвийн талаар санал бодлоо солилцлоо.

БНХалимаг Улсын тэргүүн К.Н.Илюмжиновыг Монгол, Халимагийн ах дүү ард түмний хамтын ажиллагааг идэвхжүүлэн хөгжүүлэх, Монголд шатрын спортыг дэмжин дэлгэрүүлэх үйлсэд оруулсан онцгой хувь нэмрийг нь өндрөөр үнэлж Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар төрийн дээд шагнал “Алтан гадас” одонгоор шагнав.

Монгол Улсын Засгийн газрын Тэргүүн шадар сайд, Монгол, Оросын ЗГХК-ын монголын хэсгийн дарга Н.Алтанхуяг ОХУ-ын БНХалимаг Улсын Тэргүүн К.Н.Илюмжиновыг хүлээн авч уулзан Монгол, Халимагийн худалдаа, эдийн засаг, боловсрол, соёл, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэх асуудлаар хэлэлцээ хийв.

Уулзалт, хэлэлцээний үеэр хоёр тал стратегийн түншлэлийн үзэл санааны дагуу идэвхтэй өргөжин хөгжиж байгаа Монгол, Оросын сайн хөршийн уламжлалт түншлэлийн харилцааны хүрээнд ОХУ-ын БНХалимаг Улстай бүх салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхийн төлөө байгаагаа илэрхийлэв.

ОХУ-ын БНХалимаг Улсын Тэргүүн К.Н.Илюмжинов өөрийн бүс нутгийн хөгжил болон Оросод сайн дураараа нэгдэж орсны 400 жилийн ойн баярыг тэмдэглэх гэж байгаагаа танилцуулав. Мөн нэрт аялагч Ф.Конюховын удирдлага дор “Торгоны их замын мөрөөр” гэсэн аялал Улаанбаатар-Астана-Элиста гэсэн чиглэлээр энэ жил зохион байгуулагдах нь чухал ач холбогдолтой гэж цохон тэмдэглэв. Монголын тал энэхүү аялалыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэхээ илэрхийлэв.

Талууд хөдөө аж ахуй, мал аж ахуй, аялал жуулчлал, соёл, боловсрол, шинжлэх ухаан зэрэг олон салбарт хамтран ажиллах тодорхой чиглэл, хэлбэрийн талаар хэлэлцэн тохиролцов.

Айлчлалын үеэр хоёр тал Монгол Улс, ОХУ-ын БНХалимаг Улсын хооронд Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан-техник, соёлын салбарт хамтран ажиллах тухай Санамж бичиг, Хөдөө аж ахуйн салбарт хамтран ажиллах тухай Протокол, Соёлын салбарт хамтран ажиллах тухай Протокол, Аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах тухай Протоколд тус тус гарын үсэг зурж, айлчлалын дүнгийн тухай хамтарсан хэвлэлийн мэдээ гаргав.

ОХУ-ын Бүгд Найрамдах Халимаг Улсын төлөөлөгчид Монгол Улсын улс төр, соёл, шинжлэх ухаан, шашин, хувийн хэвшлийн төлөөлөгчидтэй уулзаж яриа хэлэлцээ хийв.

БНХалимаг Улсын Тэргүүн, Дэлхийн Шатарын Холбооны ерөнхийлөгч К.Н.Илюмжинов Монголын шатрын Холбооны удирдлагатай уулзаж, өсвөрийн шатарчидтай зэрэг тоглолт хийлээ.

Айлчлалын үеэр БНХалимаг Улсын Тэргүүнийг дагалдан ирсэн Халимагийн урлагийн мастеруудын концерт, театрчилсан үзүүлбэр тоглож, “Халимаг Улс-газар нутаг, хүн ард” гэрэл зургийн үзэсгэлэн гаргав.

ОХУ-ын Бүгд Найрамдах Халимаг Улсын Тэргүүн К.Н.Илюмжинов Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр, Монгол Улсын Тэргүүн шадар сайд Н.Алтанхуяг нарыг ОХУ-ын Бүгд Найрамдах Халимаг Улсад албан ёсоор айлчлахыг урив.

ОХУ-ын Бүгд Найрамдах Халимаг Улсын Тэргүүн К.Н.Илюмжиновын энэхүү айлчлал нь түүхэн гарал, соёл иргэншил нэгтэй монгол, халимагийн ард түмний найрамдалт харилцааны цаашдын хөгжил, үндэсний уламжлал, эх хэлээ хадгалан үлдэх, сэргээх болон соёл, шашин зэрэг салбарын хамтын ажиллагааг шинэ агуулгаар баяжуулан хөгжүүлэхэд чухал түлхэц үзүүлэв.

Улаанбаатар хот  
2009 оны 2 дугаар сарын 4-ний өдөр